



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 369

Улаанбаатар хот

Дуудлагын худалдаа зохион байгуулах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 59,950,200.00 (тавин есөн сая есөн зуун тавин мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Т.Ганзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оролцуулан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТАЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001286

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн  
369. дугаар тогтоолын хавсралт

"АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ  
ЖАГСААЛТ

| №        | Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар | Toо хэмжээ | Үйлдвэрлсэнсэн, ашиглалтанд орсон | Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл               | Дуудлагаар худалдах доод үнэ |
|----------|---|------------|-----------------------------------|--|------------------------------|
|          |   | (ш)        | (огноо)                           | (төгрөг)   |                              |
| 1        | Авто кран 5тн, 18-80 ГАУ, LLTCG34E3CJ001280 | 1          | 2012/2012                         | 59,950,200.00  | 5,000,000.00                 |
|          |   |            |                                   | 59,950,200.00  | 5,000,000.00                 |
| НИЙТ ДҮН |   |            |                                   | (тавин есөн сая<br>есөн зуун тавин<br>мянга хоёр зуун) | (таван сая)                  |